



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/14

Чингис хот

Мэдээллийн самбар худалдан авах тухай


Монгол Улсын Засаг нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, агаар, ус, хөрсний бохирдол болон орчны хяналт шинжилгээний мэдээллийг орон нутгийн иргэд олон нийтэд хүргэх, сэрэмжлүүлэх, орчны бохирдлоос сэргийлэх мэдлэг олгох зорилгоор аймгийн Ус, цаг уурын орчны шинжилгээний төвийн үйл ажиллагаанд ашиглагдах орчин үеийн ухаалаг, электрон компьютер бүхий самбарыг худалдан авахад 3000000 /гурван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны
...01... дугаар сарын ...12... өдрийн ...А/14...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ухаалаг мэдээллийн самбар	ш	1	3000000	3000000
					3000000